



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчөөс
2020 онд хувьчлах эд хөрөнгийн
жагсаалтын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчөөс 2020 онд хувьчлах зарим эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор дэмжсүгэй.

2. Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2020 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбатад зөвлөмж болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

900201

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны
04 дүгээр сарын 21-ний өдрийн 147 дугаар тогтоолын
хавсралт

Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчөөс 2020 онд хувьчлах эд хөрөнгө

Д/д	Хувьчлах эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрх зүйн акт, дугаар, огноо	Байршил	Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт	Талбайн хэмжээ /м.кв/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Хувьчлагдах эд хөрөнгийн дүн /ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ/ /мян.төг/	Хувьчлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр
1	Автомашинны дулаан зогсоол	Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 96 дугаар тогтоол	Дархан сум, 6-р баг, 710 дугаар байрны доорх	Автомашинны дулаан зогсоол	172.25	ш	13	9,771.8	127,033.7	II-III улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа
2	Орон сууц	Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 46 дугаар тогтоол	Дархан сум, 16-р баг, 28-р байр, 41 тоот	Орон сууц	62.52	ш	1	16,417.9	16,417.9	II-III улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа
3	Орон сууц	Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 46 дугаар тогтоол	Дархан сум, 16-р баг, 7-р байр, 36 тоот	Орон сууц	73.56	ш	1	41,746.3	41,746.3	II-III улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа
4	Орон сууц	Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 46 дугаар тогтоол	Дархан сум, 16-р баг, 23-р байр, 31 тоот	Орон сууц	72.36	ш	1	41,402.9	41,402.9	II-III улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа